

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/007/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Дарга, Тэргүүлэх аудитор Утас: 327734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 315558 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхдэлгэр Утас: 325093 Цахим хаяг: Munkhdelgerd@audit.gov.mn Аудитор: Б.Тэгшлхам Утас: 325093 Цахим хаяг: tegshlkhamb@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ЖДҮДТ	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НА	Нотлох ажил
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
СА	Санхүүгийн аудит
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соблын төв өргөө Г корпус, 5 давхар,
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026 03 25 № 1020

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА
С.ДАВААСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн Багануур дүүргийн 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөөг 34,654.0 сая төгрөг төвлөрүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 35,498.2 сая төгрөгөөр бүрдэж төлөвлөснөөс 844.2 сая төгрөгөөр буюу 2.0 хувиар давуулсан биелэлттэй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд 35,011.4 сая төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд түүнд 3 удаа тодотгол хийж, 7,339.7 сая төгрөгөөр буюу 120.9 хувиар нэмэгдүүлэн 42,351.1 сая төгрөгөөр баталжээ. Үйл ажиллагаандаа 34,608.2 сая төгрөгийн төсөв зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 11.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

1420051988
© Ulaanbaatar / Capital City of Mongolia 2025

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

ДД	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		10,332,632.2	11,596,164.9
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	9,248,011.9	9,831,268.7
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	408,724.3	610,465.3
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	-	113,815.3
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	675,896.0	1,040,615.6
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		46,615,742.8	48,980,488.5
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	46,615,742.8	48,980,488.5
8	1.2.2.02 Биет хөрөнгө		29,753,502.5	29,222,159.8
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	1,738,571.8	1,762,413.0
10	1.2.2.04 Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	15,123,668.6	17,995,915.7
11	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		56,948,375.1	60,576,653.4
12	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		4,577,458.1	7,563,267.1
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		4,577,458.1	6,171,382.9
14	2.1.1.03 Өглөг		1,566,490.9	3,532,282.9
15	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	3,010,967.2	2,639,099.9
16	2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		-	1,391,884.2
17	2.1.2.02 Урт хугацаат зээл	20а, 20б	-	1,391,884.2
18	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		52,370,916.9	53,013,386.4
19	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		52,370,916.9	53,013,386.4
20	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		12,282,065.7	12,282,065.7
21	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/		18,670,309.9	19,379,858.9
22	2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		1,041,551.3	1,041,551.3
23	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		8,205,912.3	8,139,771.6
24	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		12,171,077.7	12,170,138.8
25	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		56,948,375.1	60,576,653.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
---	-------------------	-----------	----------------------	----------------------

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		51,504,411.1	52,355,420.9
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		19,216,632.2	22,053,019.6
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		16,414,703.5	19,299,294.4
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		16,414,703.5	19,299,294.4
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		594,380.8	604,417.9
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		2,207,548.0	2,149,307.2
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	25,128,973.5	30,302,401.4
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		-	4,184,563.8
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		7,158,805.3	-
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	41,218,904.0	51,222,243.6
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		41,218,904.0	45,471,561.1
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		37,854,871.6	45,281,327.0
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		6,417,731.2	8,203,109.1
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		769,958.1	964,590.6
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,940,717.1	4,963,928.2
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		1,262,235.6	1,880,966.4
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		-	29,514.6
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		538,863.5	810,414.1
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		158,951.3	28,898.3
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		20,492,576.5	24,288,227.7
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		4,273,838.4	4,111,678.1
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,364,032.4	190,234.1
23	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		-	5,750,682.5
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		10,285,507.1	1,133,177.3
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		3,931,559.5	1,039,344.1
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		(3,931,559.5)	(1,039,344.1)
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		6,353,947.6	93,833.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	45,976,959.3	45,976,959.3
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	20,496.7	20,496.7
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	45,997,455.9	45,997,455.9
4	1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(486.6)	(486.6)
5	1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт	20,000.0	20,000.0
6	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	6,353,947.6	6,353,947.6
7	1.1.1.1 2024 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	52,370,916.9	52,370,916.9
8	1.1.1 2025 оны 1 сарын 1-нээрх үлдэгдэл	52,370,916.9	52,370,916.9
9	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(351,190.6)	(351,190.6)
10	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52,019,726.3	52,019,726.3
11	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(938.9)	(938.9)
12	1.5 Өмчид гарсан өөрчлөлт	900,765.7	900,765.7
13	1.7 Тайлант үеийн үр дүн	93,833.2	93,833.2
14	1 2025 оны 12 сарын 31-наарх үлдэгдэл	53,013,386.4	53,013,386.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12 дугаар сарын 31	2025 оны 12 дугаар сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	50,681,647.6	52,729,807.1
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	19,216,632.2	22,053,019.6
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	16,414,703.5	19,299,294.4
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	594,380.8	604,417.9

5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	2,207,548.0	2,149,307.2
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	737,591.6	749,450.3
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	1,445,890.5	1,375,856.9
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	24,065.9	24,000.0
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,306,210.0	30,676,787.5
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	17,883,566.2	21,254,173.8
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	4,184,563.8
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	6,422,643.9	5,238,049.9
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,158,805.3	-
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,818,896.8	43,131,058.4
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	35,818,896.8	43,131,058.4
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35,074,229.9	42,941,045.0
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,809,469.9	16,684,620.9
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,514,284.3	964,508.1
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,373,876.9	5,185,520.3
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	2,776,532.1	1,925,687.9
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	1,140.0	17,799.6
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	547,629.9	1,085,104.3
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	158,951.3	28,898.3
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,562,938.6	16,038,706.4
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	1,329,407.0	1,010,199.1
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	744,666.9	190,013.3
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	14,862,750.8	9,598,748.7
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	10,711,061.1	9,015,492.0
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,711,061.1	9,015,492.0
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	10,711,061.1	9,015,492.0
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(10,711,061.1)	(9,015,492.0)
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	307,673.4	-
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(307,673.4)	-

34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,844,016.3	583,256.8
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,403,995.7	9,248,011.9
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,248,011.9	9,831,268.7

2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	34,654,018.0	35,498,198.5	844,180.5	102.4
2	3.1.01.1.1 Татварын орлого	21,832,094.5	22,053,019.6	220,925.1	101.0
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	19,023,124.0	19,299,294.4	276,170.4	101.5
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	19,023,124.0	19,299,294.4	276,170.4	101.5
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	16,280,400.0	16,881,215.0	600,815.0	103.7
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	280,000.0	315,881.2	35,881.2	112.8
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	820,000.0	840,207.1	20,207.1	102.5
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	800,000.0	671,752.7	(128,247.3)	84.0
9	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	842,724.0	590,238.5	(252,485.6)	70.0
10	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	551,918.8	604,417.9	52,499.1	109.5
11	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	420,000.0	465,678.2	45,678.2	110.9
12	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	14,000.0	14,235.0	235.0	101.7
13	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	117,918.8	124,504.8	6,586.0	105.6
14	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	2,257,051.7	2,149,307.2	(107,744.5)	95.2
15	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	748,600.0	749,450.3	850.3	100.1
16	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	210,000.0	188,659.7	(21,340.3)	89.8
17	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	538,600.0	560,790.6	22,190.6	104.1
18	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	1,484,451.7	1,375,856.9	(108,594.8)	92.7
19	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	1,484,451.7	1,375,856.9	(108,594.8)	92.7
20	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	24,000.0	24,000.0	-	100.0
21	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	24,000.0	24,000.0	-	100.0
22	3.1.01.1.2 Татварын бус орлого	12,821,923.5	13,445,178.9	623,255.4	104.9
23	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	4,562,500.0	5,236,060.8	673,560.8	114.8

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

24	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	2,650,000.0	3,259,816.4	609,816.4	123.0
25	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	307,500.0	297,921.3	(9,578.7)	96.9
26	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	1,605,000.0	1,678,323.1	73,323.1	104.6
27	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	2,971,068.2	2,971,068.2	-	100.0
28	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	2,971,068.2	2,971,068.2	-	100.0
29	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	5,288,355.3	5,238,049.9	(50,305.4)	99.0
30	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	5,288,355.3	5,238,049.9	(50,305.4)	99.0
31	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,351,134.5	34,608,238.8	(7,742,895.7)	81.7
32	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	27,950,620.4	26,098,031.6	(1,852,588.8)	93.4
33	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,345,248.7	25,572,493.8	(1,772,754.9)	93.5
34	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,887,926.5	8,164,026.4	(723,900.1)	91.9
35	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	3,719,444.5	3,570,872.6	(148,571.9)	96.0
36	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	1,988,308.7	1,794,397.7	(193,911.0)	90.2
37	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	1,961,388.4	1,773,795.2	(187,593.2)	90.4
38	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	703,386.1	513,254.3	(190,131.8)	73.0
39	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	515,398.8	511,706.6	(3,692.2)	99.3
40	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,102,385.2	964,508.1	(137,877.1)	87.5
41	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	744,932.5	657,847.9	(87,084.7)	88.3
42	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	88,824.7	80,254.2	(8,570.5)	90.4
43	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	45,385.8	41,139.9	(4,245.9)	90.6
44	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	44,742.8	36,191.7	(8,551.1)	80.9
45	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	178,499.4	149,074.5	(29,424.9)	83.5
46	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,665,345.7	4,963,802.7	(701,543.0)	87.6
47	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	1,376,008.4	1,289,586.1	(86,422.3)	93.7
48	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	3,432,071.8	2,878,278.8	(553,793.0)	83.9
49	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	857,265.5	795,937.7	(61,327.8)	92.8
50	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	1,822,109.6	1,808,763.1	(13,346.5)	99.3
51	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	36,050.0	29,542.8	(6,507.2)	81.9
52	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	47,650.0	46,299.3	(1,350.7)	97.2
53	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	55,568.6	52,700.2	(2,868.4)	94.8
54	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,595,810.7	1,595,376.6	(434.1)	100.0
55	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	87,030.3	84,844.2	(2,186.1)	97.5
56	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	3,000.0	3,000.0	-	100.0

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

57	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000.0	3,000.0	-	100.0
58	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	757,825.4	805,585.3	47,759.9	106.3
59	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	25,200.0	22,055.9	(3,144.1)	87.5
60	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,100.0	4,100.0	-	100.0
61	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	728,525.4	779,429.4	50,904.0	107.0
62	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	40,250.0	28,898.3	(11,351.7)	71.8
63	3.1.01.2.1.1.7.01 Гадаад албан томилолт	30,000.0	21,160.3	(8,839.7)	70.5
64	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	10,250.0	7,738.0	(2,512.0)	75.5
65	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,870,661.3	7,788,437.2	(82,224.1)	99.0
66	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,847,494.8	7,765,880.2	(81,614.6)	99.0
67	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	1,880.9	1,768.2	(112.7)	94.0
68	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	5,794.3	5,631.2	(163.1)	97.2
69	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношилгоо	189.0	22.0	(167.0)	11.6
70	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,400.0	7,399.9	(0.1)	100.0
71	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	7,902.3	7,735.8	(166.6)	97.9
72	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	1,195,745.0	1,045,472.8	(150,272.3)	87.4
73	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	1,192,170.0	1,041,951.2	(150,218.8)	87.4
74	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,575.0	3,521.5	(53.5)	98.5
75	3.1.01.2.1.3 ТАТААС	335,524.5	335,524.5	-	100.0
76	3.1.01.2.1.3.1 Төрийн өмчит байгууллагад олгох татаас	335,524.5	335,524.5	-	100.0
77	3.1.01.2.1.3.1.01 Төрийн өмчит байгууллагад олгох татаас	335,524.5	335,524.5	-	100.0
78	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	269,847.2	190,013.3	(79,833.9)	70.4
79	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	269,847.2	190,013.3	(79,833.9)	70.4
80	3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,500.0	4,500.0	-	100.0
81	3.1.01.2.1.4.2.06 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	147,541.2	86,246.4	(61,294.9)	58.5
82	3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	57,556.0	57,428.5	(127.5)	99.8
83	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,250.0	41,838.5	(18,411.5)	69.4
84	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,400,514.1	8,510,207.2	(5,890,306.9)	59.1
85	3.1.01.2.2.1 Барилга байгууламж	6,446,194.4	5,405,937.5	(1,040,256.9)	83.9

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

86	3.1.01.2.2.2 Их засвар	2,478,173.5	1,275,193.2	(1,202,980.3)	51.5
87	3.1.01.2.2.3 Тоног төхөөрөмж	3,392,723.2	1,349,249.8	(2,043,473.4)	39.8
88	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	2,083,423.0	479,826.8	(1,603,596.3)	23.0
89	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(7,697,116.5)	889,959.7	8,587,076.2	(11.6)
90	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,697,116.5	(889,959.7)	(8,587,076.2)	(11.6)
91	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	7,697,116.5	(889,959.7)	(8,587,076.2)	(11.6)
92	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,759,566.4	7,759,566.4	
93	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	8,707,095.1	8,707,095.1	
94	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	547	519.0	(28.0)	94.9
95	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	7	7	-	100.0
96	6.1.01 Төсвийн байгууллага	7	7	-	100.0
97	6.2 АЖИЛЛАГСДЫН ТОО	270	256	(14.0)	94.8
98	6.2.01 Удирдах ажилтан	28	28	-	100.0
99	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	143	133	(10.0)	93.0
100	6.2.03 Үйлчлэх ажилтан	63	60	(3.0)	95.2
101	6.2.04 Гэрээт ажилтан	36	35	(1.0)	97.2
102	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	270	256	(14.0)	94.8
103	6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	79	67	(12.0)	84.8
104	6.5.02 Төрийн тусгай албан хаагч (ТТ)	6	4	(2.0)	66.7
105	6.5.06 Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	25	25	-	100.0
106	6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	111	111	-	100.0
107	6.5.10 Гэрээт ажилтан	36	35	(1.0)	97.2
108	6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ)	13	14	1.0	107.7

2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,204,355,589.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,204,355,589.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,204,355,589.03
210402	Тээвэр, шатахуун	2,002,320.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,621,000.00
2105	Хоол хүнсний	14,799,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	138,646,839.00
210604	Урсгал засвар	169,856,556.21

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	826,273,793.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	826,273,793.82
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,655,480.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,655,480.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,261,924,666.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,261,924,666.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	110,826,092.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,429,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,102,669,474.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	57,569,076.97

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Багануур дүүрэг нь эрхэм зорилгоо “*Бүтээн байгуулалтын жил болгох*” гэж тодорхойлсон байна.

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дараах зорилгыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал санаачилга гаргасан бизнес эрхлэх хүсэлтэй залуучуудад дэмжлэг үзүүлж ажиллана;
- Ажлын байрыг нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулна;
- Бүсчилсэн хөгжлийн бодлого (48 арга хэмжээ);
- Хүний хөгжлийн бодлого (123 арга хэмжээ);
- Эдийн засгийн бодлого (44 арга хэмжээ);
- Ногоон хөгжлийн бодлого (22 арга хэмжээ);
- Засаглалын бодлого (58 арга хэмжээ).

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг дарга нь дүүргийн үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэл тайлагналд МУ-ын Үндсэн хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТ, Төрийн хэмнэлтийн тухай, Захиргааны ерөнхий хууль, Аудитын тухай хууль, Шилэн дансны тухай,

Хөдөлмөрийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Боловсролын тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Татварын ерөнхий хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Авлигын эсрэг хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Архив албан бичиг хэрэг хөтлөлтийн тухай хууль, болон бусад тогтоомж, журам, шийдвэрүүдийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант онд дараах хууль, тогтоомж, болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт;
- Төсвийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт;
- ЗГ-ын 2025 оны 17 дугаар тогтоол “Төрд учирсан хохирлыг барагдуулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай”;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаал “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/112 дугаар тушаал “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай”.

Нийслэлийн Багануур дүүргийн Дотоод аудитын алба нь Дотоод аудитын хорооны баталсан 2025 оны аудит, хяналт шалгалт, зөвлөн туслах ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу төлөвлөгөөт 12, төлөвлөгөөт бус 1 аудит, хяналт шалгалт гүйцэтгэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 100% хэрэгжүүлж ажилласан байна. Хяналт шалгалтаар нийт 16,442,925.0 төгрөгийн зөрчлийг илрүүлж, 2 албан шаардлага хүргүүлж, 166 зөвлөмж өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаар албан шаардлага 45.0 хувь, зөвлөмж 84.0 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 26 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 97 гүйлгээ, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 5 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 31 шийдвэрийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. (ДАА, ХААА, СО, УСБТ, ЖДУДТ)

4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2054 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар төсвийн шууд захирагч нь тайлант жилийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа тендер зарлаагүй, хэсэгчлэн хувааж шууд гэрээ байгуулсан, төсөвт өртгийн дээд хязгаараас давсан худалдан авалтыг нэг эх үүсвэрээс зэрэг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2-т "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" журамд заасныг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох шалгуурт, Төрийн хэмнэлтийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

Нийслэлийн Багануур дүүргийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 8 төсвийн байгууллага, 2 сан, зардал, 4 ААТҮГ-ын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 14 байгууллага, сан аудитад хамрагдсан. Үүнд: Орон нутгийн төсвийн 8 байгууллага (ИТХ, ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, Дотоод аудитын алба, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв, Усан спорт боулингийн төв, Соёлын ордон, Теле камерын хяналтын дэд төв), 2 сан (ОНХС, Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал), 4 ААТҮГ (Багануур Залуус төв, Багануур дүүргийн Тээвэр зохицуулалтын алба, Багануур-Ус, Багануур тохижилт)-ын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	НТАГ-аас дүгнэлт гаргасан	Аудитын хуулийн этгээдээр гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	2	-	8	-
2	ОНӨҮГ	-	4	-	-
	Дүн	2	4	8	

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" 5 (ИТХ, Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ, Багануур-Ус, Багануур тохижилт ААТҮГ, Багануур Залуус төв ААТҮГ.), "Хязгаарлалттай" 1 (ЗДТГ) дүгнэлт өгсөн.

5.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын эрхлэх хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,567,626.7 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулж, 2,699.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 232,473.5 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 125,580.6 мянган төгрөгийн 20 зөвлөмж өгсөн.

5.2 Төсвийн төвлөрүүлэн захирагч

Аудитаар нийт 22,024.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 22,024.5 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд төлөвлөгөөт зардлын ангиллыг 21,176.0 мянган төгрөгөөр зөрүүлэн нэгтгүүлсэн байна.
- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 621.5 мянган төгрөгөөр, өр төлбөр 227.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2. "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" заалттай нийцээгүй, АОУС-450 "Аудитын явцад илрүүлсэн буруу илэрхийллийг үнэлэх А9. "Аудиторын танилцуулсан буруу илэрхийллийг оролцуулаад бүх буруу илэрхийллийг удирдлага залруулах нь нягтлан болох бүртгэл хөтлөлт, бичилтийг зөв хийх, өмнөх үетэй холбоотой материаллаг бус залруулагдаагүй буруу илэрхийллийн хуримтлагдсан үр нөлөөний улмаас ирээдүйн санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэл гарах эрсдэлийг бууруулах боломжийг удирдлагад олгоно" стандарт болон санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар нийт 90,962.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 33,393.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 57,569.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

5.2.1 Төлбөрийн акт

Хөрөнгө оруулалтаар 2022-2023 онуудад хийгдэж дууссан, ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгааны хугацаа дууссан, ашиглагч байгууллагаас баталгаа зөвшөөрөл ирээгүй, гүйцэтгэгч ААНБ-уудаас хүсэлт материал бүрдүүлж өгөөгүй нийт 33,393.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх" 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" заасантай тус тус нийцээгүй, УСНББОУС-30 Санхүүгийн хэрэглүүр: тодруулга MNS-6817-4:2020 стандарт болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө оруулалтын ажлын чанарын баталгааны хугацаа дууссан, барьцааг орлогын нэгдсэн дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт 1: Дүүргийн харьяа байгууллагууд төсвийг үрэлгэн зарцуулж төрийн хэмнэлтийн тухай хууль болон түүний хэрэгжилттэй холбоотой албан даалгаврын зарим заалтыг хангаагүй, худалдан авалтыг холбогдох хууль, заавар журмын дагуу хийгээгүй, авлага өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй өмнөх оноос нэмэгдүүлсэн, элэгдлээрээ анхны хөрөнгөө нөхсөн хөрөнгүүдийн ашиглалт, хадгалалтыг үнэлээгүй, өмнөх аудитын зөвлөмж хэрэгжүүлээгүй, төсөвт байгууллагын жижиг мөнгөн сангийн журам хүчингүй болсон байхад үйлчилгээний орлогыг бэлэн мөнгөөр тооцсон, зэрэг зөрчлүүд гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "*төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх*", 16 дугаар зүйлийн 16.5.2-д "*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дүүргийн харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаа, тайлагналд тавих дотоод хяналтыг сайжруулж, аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хянат хэрэгжүүлэн үр дүнг тайлагнах зөвлөмж өгөв.

Илрүүлэлт 2: Төсвийг зөв зохистой удирдаагүй, жилийн төсөвтөө багтаан 57,569.1 мянган төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", заасантай нийцээгүй, УСНББОУС 29 "*Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт,*" стандарт болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Багануур дүүргийн ТТЗ	2	22 024.5			2	22 024.5	2	22 024.5				
1	Багануур дүүргийн ИТХ	1	763 837.2			1	763 837.2	1	763 837.2				
2	Багануур дүүргийн ЗДТГ	2	1,663,800.7			2	1,663,800.7	2	1,663,800.7				
3	Багануур дүүргийн Дотоод аудитын алба							1	8,057.9				
4	Багануур дүүргийн Худалдан авах ажиллагааны алба												
5	Багануур дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв												
6	Багануур дүүргийн Соёлын ордон	1	6,038.8			1	6,038.8	1	6,038.8				
7	Багануур дүүргийн Усан спорт боулингийн төв	2	7,090.8			2	7,090.8	2	7,090.8				
8	Теле камерын хяналтын дэд төв	1	6,790.0			1	6,790.0	1	6,790.0				
9	Багануур дүүргийн ОНХС												
10	Багануур дүүргийн Хөрөнгө оруулалт												
	Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	9	2,469,582.0			9	2,469,582.0	9	2,469,582.0				
11	Багануур Залуус төв ААТҮГ	1	920.0			1	920.0	1	920.0				
12	Багануур дүүргийн Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ	1	31,382.5			1	31,382.5	1	31,382.5				
13	Багануур-Ус ААТҮГ	3	873,016.3			3	873,016.3	3	873,016.3				
14	Багануур тохижилт ААТҮГ	2	214,750.4			2	214,750.4	2	214,750.4				
	ОНӨҮГ-ын дүн	7	1,120,069.2			7	1,120,069.2	7	1,120,069.2				
	НИЙТ ДҮН	16	3,589,651.2			16	3,589,651.2	16	3,589,651.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
	Багануур дүүргийн ТТЗ	3	90,962.8	1	33,393.7			2	57,569.1				
1	Багануур дүүргийн ИТХ	3	12,191.1					3	12,191.1				
2	Багануур дүүргийн ЗДТГ	8	228,870.3	1	1,511.0	1	188,845.1	6	38,514.2				
3	Багануур дүүргийн Дотоод аудитын алба	1	-					1	-				
4	Багануур дүүргийн Худалдан авах ажиллагааны алба												
5	Багануур дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв												
6	Багануур дүүргийн Соёлын ордон	1	3,420.0					1	3,420.0				
7	Багануур дүүргийн Усан спорт боулингийн төв	2	32,927.7					2	32,927.7				
8	Теле камерын хяналтын дэд төв												
9	Багануур дүүргийн ОНХС												
10	Багануур дүүргийн Хөрөнгө оруулалт												
	Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	18	368,371.9	2	34,904.7	1	188,845.1	15	144,622.1				
11	Багануур Залуус төв ААТҮГ	2	7,087.2					2	7,087.2				
12	Багануур дүүргийн Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ	3	4,763.8			1	1,388.4	2	3,375.4				
13	Багануур-Ус ААТҮГ	4	29,253.9	1	1,188.9	1	-	2	28,065.0				
14	Багануур тохижилт ААТҮГ	2	42,240.0			1	42,240.0	1	-				
	ОНӨҮГ-ын дүн	11	83,344.9	1	1,188.9	3	43,628.4	7	38,527.6				
	НИЙТ ДҮН	29	451,716.8	3	36,093.6	4	232,473.5	22	183,149.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Багануур дүүргийн ТТЗ								
1	Багануур дүүргийн ИТХ								
2	Багануур дүүргийн ЗДТГ								
3	Багануур дүүргийн Дотоод аудитын алба	1	-					1	-
4	Багануур дүүргийн Худалдан авах ажиллагааны алба	1	-					1	-
5	Багануур дүүргийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв	1	-					1	-
6	Багануур дүүргийн Соёлын ордон	1	-					1	-
7	Багануур дүүргийн Усан спорт боулингийн төв	1	-					1	-
8	Теле камерын хяналтын дэд төв								
9	Багануур дүүргийн ОНХС								
10	Багануур дүүргийн Хөрөнгө оруулалт								
	Орон нутгийн төсвийн байгууллагуудын дүн	5	-					5	-
11	Багануур Залуус төв ААТҮГ								
12	Багануур дүүргийн Тээвэр зохицуулалтын алба ААТҮГ								
13	Багануур-Ус ААТҮГ	1	253,500.0			1	253,500.0		
14	Багануур тохижилт ААТҮГ	2	4,421.7	1	921.7	1	3,500.0		
	ОНӨҮГ-ын дүн	3	257,921.7	1	921.7	1	3,500.0		
	НИЙТ ДҮН	8	257,921.7	1	921.7	2	257,000.0	5	-



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 231 /А/230101

Улаанбаатар хот

НТАГ-2026/007/НА-СТА-ТТ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Багануур дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтаар 2022-2023 онуудад хийгдсэн, ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгааны хугацаа дууссан, ашиглагч байгууллагаас баталгаа, зөвшөөрөл ирээгүй, гүйцэтгэгч ААНБ-аас хүсэлт ирээгүй нийт 33,393,714.00 (зучин гурван сая гурван зуун ерэн гурван мянга долоон зуун арван дөрөв) төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "харилцлагатай байх" 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захирагчаны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөрөнгө оруулалтын ажлын чанарын баталгааны хугацаа дууссан, ашиглагч, гүйцэтгэгч байгууллага ААН-үүдээс хүсэлт ирүүлээгүй 33,393,714.00 (зучин гурван сая гурван зуун ерэн гурван мянга долоон зуун арван дөрөв) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ, хүү торгуулийн орлогын MN440090100200000008 дугаар дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ний дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Багануур дүүргийн Засаг дарга С.Даваасүрэн, Төрийн сангийн хэлтсийн дарга Н.Оюунцэцэг, ерөнхий нягтлан бодогч Д.Мөнхзул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Я.АЛТАНЦЭЦЭГ
Б.ТЭГШЛХАМ

1 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Б.корпус, 5 давхар

1426110249